

УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР НЯМБАЙ ОЙДОВ

Ойдов нийслэлийн нэгэн сургуулийн тавдугаар ангид сурдаг. Онцгой авьяасгүй ч нямбай зантай жаал. Амралтын энэ өдөр тэр гайхмаар эрт босжээ. Уг нь ч үд болтол унтдаг нойр ихтэй хүүхэд л дээ. Тэгээд босонгуутаа л -Ээжээ! Та өнөөдөр надад “Баавгайг яаж барьсан бэ?” гэдэг номыг заавал олж өгөөрэй. Энэ номыг уншаад тэмдэглэл хөтлөх ёстой. Их ховор ном гэсэн шүү гэж ээждээ үүрэг өгчээ. Ээж нь ч тэр даруй ийш тийш нь утасдаж эрэл сурал болж гэнэ. Ашгүй тэгтэл ээжийнх нь нэг найз нь,



- Манайд байж байна шүү, энэ ном чинь. Амралтын өдөр ч тоглож наадахгүй. Хичээл ном гээд л танай хүү сүрхий юмаа гэсээр орж ирлээ. Ойдов ингээд даалгавраа хийхээр өрөөндөө орж ширээнийхээ ард тухлан суулаа. Гэтэл уншихаар дэлгэсэн номынх нь хуудас бүхэн дээр өнгө өнгийн харандаагаар янз бүрийн зураг зурчихсан байх юм. Бүр зарим хуудсан дээр нь зүгээр л учир нь олдохгүй зүйл эрээччихсэн байлаа. Ойдов хүү цэвэрч нямбай гэж би та нарт хэлсэн шүү дээ.



Унших ном маань үзэмжгүй байх нь, угаасаа л миний сэтгэлд нийцэхгүй гэж Ойдов өөртөө хэлээд эрхийн чинээ баллуур авч элдвийн зургуудыг баллуурдаж гарлаа. Зураас бүрээр нь нямбай баллуурдахад зугаатай бас урамтай байжээ. Хамгийн сүүлчийн зургийг баллуурдаж дуусахад нар хэдийнээ баруунаа хэлбийсэн байв. Ээж нь өрөө рүү нь шагайгаад, аяга цай ч уулгүй өдөржин ном уншлаа. Одоо миний хүү түр амсхийгээд оройн хоолоо ид гэв. Таатай энэ үгийг сонсоод Ойдов жигтэйхэн их өлссөнөө мэдлээ. Оройн хоолоо идчихээд зурагтын суваг баахан сольж буйдан дээр хэсэг тарвалзсанаа даалгавраа хийхээр өрөөндөө орлоо.



-За ёстой уншиж гарна даа гээд номоо дэлгэтэл хатуу хавтас нь салаад уначихжээ. Сая баллуурдахдаа салгаж орхив уу? Сахилгагүй жаал өмнө нь урчхав уу? Замбараагүй явдалд би дургүй цавуудаж сайн наах л хэрэгтэй. Ойдов ийнхүү бодоод цаасны цавууны эрэлд гарлаа. Уйгагүй хайсны эцэст цаасны цавуугаа олсон ч хаанаас нь яаж наах учраа ололгүй баахан гайхаж суув гэнэ. Үнэндээ зузаан номны хавтсыг салж унахааргүй наана гэдэг зураас баллуурдахаас амаргүй ажээ. Ховор номын дээлийг сэлбэх хосгүй ажил арай гэж дуусахад оддын түрүүч түгж үдэш болсон байлаа. Гэтэл түүний өрөөнд ээж нь орж ирлээ. Тэгээд Ойдовын толгойг илж, иш хүү минь бүр ядарчхаж. Өглөөнөөс үдэш хүртэл ном уншлаа. Одоо бараг наад номоо цээжлээ байлгүй. Унтаж амар хүү минь гэжээ. Ээжийнхээ энхрийлж хайрласан үгсийг Ойдов сонсоод л өөрийн эрхгүй нойр нь хүрч нүд нь анилдан ор уруугаа зүтгэж гэнэ дээ.

О.Сундуй



1. "нар баруунаа хэлбийх" үгийн утгад тохирох хэсгийг сонгоно уу.

- A. үд өнгөрч нар гудайх
- B. үдийн өмнө нар гудайх
- C. үд өнгөрч нар мандах
- D. үд өнгөрч нар шингэх

2. "Ойдовын өрөөний үүдийг **шагай.**",
"**Шагай таалцах уу?**" гэсэн өгүүлбэрүүдийн тодруулсан үгс ямар утгатай үгс вэ?

- A. зэрэгцсэн утгатай үг
- B. ойролцоо утгатай үг
- C. салаа утгатай үг
- D. эсрэг утгатай үг



3. "Ойдов **хэзээ?** даалгавраа хийхээр **хаана?** орж **хаана?** тухлан суулаа." гэсэн өгүүлбэрийн тодруулсан асуултанд хариулагдах бүлэг үгсийг сонгоно уу.

A. нар баруунаа хэлбийхэд, өрөөндөө, ширээнийхээ ард

B. өглөө эрт, гэртээ, буйдан дээрээ

C. өглөө эрт, өрөөндөө, ширээнийхээ ард

D. өглөө эрт, ширээнийхээ ард, өрөөндөө

4. "Уйгагүй хайсны **эцэст нь** цаасны цавуугаа олсон ч хаанаас нь яаж наах учраа ололгүй баахан гайхаж суув гэнэ." өгүүлбэрийн тодруулсан үгийг ямар төрлийн холбоос болохыг сонгоно уу.

A. Лавшруулсан

B. харьцуулсан

C. цаг хугацааны

D. эсрэгцүүлсэн



5. Ойдовын хийсэн үйлийг зөв дараалуулсан хэсгийг сонгоно уу.

А. зузаан номын хавтас наасан, нойр нь хүрч унтаж амарсан, номны эрээчсэн . зураг баллуурдсан, ээжээрээ ховор ном олуулсан

В. ээжээрээ ховор ном олуулсан зузаан номын хавтас наасан, номны эрээчсэн . зураг баллуурдсан, , нойр нь хүрч унтаж амарсан,

С. номны эрээчсэн зураг баллуурдсан, зузаан номын хавтас наасан, нойр нь . хүрч унтаж амарсан, ээжээрээ ховор ном олуулсан

Д. ээжээрээ ховор ном олуулсан, номны эрээчсэн зураг баллуурдсан . зузаан номын хавтас наасан, нойр нь хүрч унтаж амарсан



6. Ээж нь **“Одоо бараг наад номоо цээжлээ байлгүй”** гэсний учир нь юу вэ?

A. Ойдовыг өдөржин өрөөндөө номоо нааж, баллуурдаж суусныг мэдсэн учраас

B. Ойдов өдөржин өрөөндөө номоо нааж, баллуурдаж суусан учраас

C. Ойдов өдөржин өрөөндөө номоо уншиж суусан учраас

D. Ойдовыг өдөржин өрөөндөө номоо уншиж суусан гэж бодсон учраас

7. Эхэд юуны тухай өгүүлж байна вэ?

A. амралтын өдөр тоглож наадах дургүй хүүхдийн тухай

B. ном уншиж тэмдэглэл хөтлөх дуртай хүүхдийн тухай

C. хэдий нямбай ч юу чухал вэ? гэдгээ гүйцэд ухаараагүй хүүхдийн тухай

D. ширээнийхээ ард тухлан суух дуртай хүүхдийн тухай



8. Эхийн утгад тохирох зүйр үгийг сонгоод өгүүлбэр зохион бичээрэй.

А. барилдахаасаа таахалзах нь,

В. хийхэд бүү залхуур үйлдэхээсээ танхилзах нь сурахад бүү мэдэмхийр

Өгүүлбэр:.....

.....

9. Ойдовын хийсэн үйлийг үнэлж дүгнэх 1 асуулт зохиогоорой.

.....

10. “Ховор номын дээлийг сэлбэх хосгүй ажил арай гэж дуусахад оддын түрүүч түгж үдэш болсон байлаа.” гэсэн өгүүлбэрээс адилтгасан дүрслэлийг олж тайлбарлаарай.

Адилтгасан дүрслэл:

.....

Тайлбар:.....

.....

